



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ХУЖИНГИЙН АЛТАНГЭРЭЛ ТАНАА**

2020.09.03 № 007-0000/06-НА-18

танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд Сүхбаатар сумаас бие даан нэр дэвшигч Хужингийн Алтангэрэлийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд Сүхбаатар сумаас бие даан нэр дэвшигч Х.Алтангэрэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020746


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Х.Алтангэрэлийн Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Х.Алтангэрэлийн мөрийн хөтөлбөр /.....^L хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ХУЖИНГИЙН АЛТАНГЭРЭЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



Уриа: Сэлэнгэ нутгаа хөгжүүлж, Сэлэнгэдээ сайхан амьдарцгаая.

1. Аймаг, орон нутагт шударга ёс тогтооход голлон анхаарч, хүний эрх, эрх чөлөөт байдлыг хамгаалах, хууль тогтоомжийн биелэлт, хэрэгжилтэд хяналт тавьж шударга ёсыг хэрэгжүүлнэ.

2. Иргэн бүрд нэг удаа үнэ төлбөргүй газар эзэмшүүлэх хуулийн хэрэгжилтийг аймагтаа бүрэн хангуулан, иргэдэд газар эзэмшүүлэх ажлыг идэвхжүүлж, сурталчлан, хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

3. Аймаг, орон нутгийн иргэдэд өгөөжгүй, байгаль орчинд хохиролтой уул уурхайн ашиглалтыг хязгаарлах, байгаль орчинд ээлтэй, малчид, тариаланчид, ард иргэдэд үр өгөөжтэй байх, газар нутгийн унаган байдлыг хадгалах бодлогыг баримтална.

4. Аймаг, орон нутагт "Ногоон хөгжил"-ийг дэмжих, үндэсний баялаг бүтээгчдэд дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлэх замаар ард иргэдээ ажилтай, орлоготой болгох, амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлээр ажиллана.

5. Аймаг, орон нутгийн төрийн байгууллагад нүүрлэсэн хулгай, үрэлгэн зарцуулалт, үр өгөөжгүй хөрөнгө оруулалтыг багасгаж, төсвийн хөрөнгийн зарцуулалтыг оновчтой болгох, ард иргэдэд бодит үр дүнгээ өгөх бодлого барьж ажиллана.

6. Орон нутгийн төрийн албанд эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашигласан албан тушаалтанд хуулийн хариуцлага тооцуулан, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий хууль, хяналтын байгууллагуудтай хамтран ажиллана.

7. Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа уул уурхайн ашиглалтын мэдээллийг ил тод болгож, ашигт малтмалын баялгаас орон нутгийн төсөвт өгөх үр өгөөжийн боломжит хэмжээг нэмэгдүүлэхийн төлөө ажиллана.

8. Боловсрол, эрүүл мэнд, даатгалын үйлчилгээг ард иргэдэд сурталчлах, хөнгөн шуурхай байх зарчим баримталж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

9.Өндөр настан, эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудад хүргэх нийгмийн болон төрийн үйлчилгээг сайжруулах, үр дүнтэй болгох бодлогыг баримтална.

10.Аймгийн хэмжээнд урт хугацаанд үр ашгаа өгөх, олон ажлын байр бий болгох, алс ирээдүйг харсан үйлдвэр байгуулах ажлыг дэмжинэ.

11.Аймгийн хэмжээний төсвийн болон бусад ажлын байр бий болгох зориулалт бүхий үйлдвэрлэлийн болон бусад дэмжих сангуудын зарцуулалт, тендер шалгаруулалтад ИТХ-ын зүгээс тавих хяналтыг сайжруулан, сонгон шалгаруулалт хуулийн дагуу шударга явагдах нөхцөлийг хангана.

12.Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг сайжруулах, даатгуулагчдад ээлтэй байх, үр өгөөжийг даатгуулагч хүртдэг болгох, нийгмийн даатгалын болон тэтгэврийн даатгалын, нийгмийн хамгааллын тогтолцоог өөрчлөхөд чиглэсэн санал, санаачилга гарган ажиллана.

Бие даан нэр дэвшигч



Х.Алтангэрэл

2020.07.23